



Байнгын хорооны хуралдааны тэмдэглэл
2025 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-14

1.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын төлөөлөгчийн газар байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага хоорондын хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2025.08.15-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/	4-14
---	------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
9 дүгээр сарын 24-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 55.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 48 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Бум-Очир;

Чөлөөтэй: Н.Номтойбаяр, Л.Оюун-Эрдэнэ, Ө.Шижир, Р.Эрдэнэбүрэн.

Нэг.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын төлөөлөгчийн газар байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага хоорондын хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2025.08.15-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Гадаад харилцааны яамны Олон талт хамтын ажиллагааны газрын дэд захирал Б.Отгонбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, зөвлөх С.Дунжидмаа, М.Отгон нар байлцав.

Хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан, Г.Очирбат нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Гадаад харилцааны яамны Олон талт хамтын ажиллагааны газрын дэд захирал Б.Отгонбаатар нар хариулж, тайлбар хийв.

Г.Тэмүүлэн: Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын төлөөлөгчийн газар байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага хоорондын хэлэлцээрийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Татгалзсан: 3
Бүгд: 24
87.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 15 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Гадаад зээл, тусламжийн хэрэгжилт, нөхцөл байдлын талаарх Сангийн сайдын мэдээллийг холбогдох сайдыг иртэл түр хойшлуулав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 32 минут үргэлжилж, 29 гишүүнээс 24 гишүүн хүрэлцэн ирж, 82.5 хувийн ирцтэйгээр 15 цаг 20 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим 14 цаг 48 минут

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн байна. Хуралдаан эхлэхэд бэлэн болсон байна. Ирцийг танилцуулъя та бүхэндээ. Очирбатын Амгаланбаатар гишүүн, Чинбаатарын Анар гишүүн, Дашдондогийн Ганбат гишүүн, Хажыкберийн Жангабыл гишүүн, Сүрэнжавын Лүндэг гишүүн, Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн, Нанзадын Наранбаатар гишүүн, Ганбатын Очирбат гишүүн, Буяагийн Тулга гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Жадамбын Энхбаяр гишүүн, Лутаагийн Энхнасан гишүүн, Дашцэрэнгийн Энхтүвшин нарын гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна аа. Ингээд 2025 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Та бүхэнд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хоёр асуудал байгаа.

Нэгдүгээрт, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага буюу FAO байгууллагын төлөөлөгчийн газар байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага хоорондын хэлэлцээрийн төслийг Засгийн газраас зөвшилцөхөөр ирүүлсэн байна аа. Тэгээд 2025 оны 8 сарын 15-ны өдөр ирүүлсэн зөвшилцөх асуудал байна.

Хоёр дахь асуудал нь мэдээлэл сонсох байгаа. Гадаадын зээл тусламж бол түүний хэрэгжилттэй холбоотой асуудлаар Байнгын хороодын гишүүдээс гаргасан саналын дагуу бас мэдээлэл сонсохоор байгаа. Ингээд энэ 2 асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу? Алга байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Нэгдүгээрх асуудал НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын төлөөлөгчийн газар байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар болон НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага хоорондын хэлэлцээрийн төслийг хэлэлцэж эхэлье. Ингээд уг хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Засгийн газрын гишүүн ХХААХҮ-ийн сайд Энхбаяр сайд танилцуулна Таныг микрофонд урьж байна.

Энэ хооронд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танхимд оруулаарай. Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Ж.Энхбаяр: Эрхэм Байнгын хороон дарга, Байнгын хорооны гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага хооронд НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын төлөөлөгчийн газрын байгууллага тухай хэлэлцээрийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн улмаар Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд зөвшилцөхөөр хүргүүлэх дараагийн шатад хэлэлцүүлэх болон Монгол Улсын Их Хурлаар соёрхон батлуулахаар энэхүү асуудлыг дэвшүүлж байна аа. Монгол Улс 1973 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын гишүүнээр элсэж өлсгөлөн, шим тэжээлийн дутагдлыг устгах хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах дэлхий нийтийн зорилгод нэгдсэн. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын тууштай хамтын ажиллагаа нь манай улсын зөвхөн ХХАА-н салбараар зогсохгүй бусад олон салбарын тогтвортой хөгжилд байнгын дэмжлэг үзүүлж ирсэн стратегийн чухал ач холбогдолтой байгууллага юм аа.

Түүхэн товчоог сөхөж үзвэл 1973 оны 10 сарын 15-ны өдөр Бүгд БНМАУ-ын Гадаад явдлын яамны сайд Лодонгийн Ринчин БНМАУ-ыг НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын гишүүн болох үед тус байгууллагын хүчин төгөлдөр байгаа дүрэмд заасан үүргийг албан ёсоор хүлээн зөвшөөрөх, түүнийг дагаж биелүүлэх тухай хүлээн зөвшөөрөх бичиг анх хүргүүлж байсан түүхтэй байна аа.

Монгол Улсын холбогдох салбаруудад үзүүлэх дэмжлэг, тусламж, ажлын ачааллаас хамааран НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Ерөнхий захирал Жак Диюф 2008 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн дугаар тоот нот бичиг. Монгол Улсын ХХАА-н сайд Ц.Ганхуягийн 2008 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн дугаар тоот хариу албан бичгээр НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас Монгол Улсад суух хөтөлбөрийн туслахын албан тушаалыг бий болгох үүнтэй холбогдон гарах зардал нөхцөлийг хангахаар харилцан ойлголцлын санамж бичиг байгуулахаар харилцан тохиролцож байсан байна. Үүний дагуу 2009 онд 1 дүгээр сарын 15-ны өдөр Монгол Улсын ХХААХҮ-ийн сайд Бадамжунай, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас Монгол Улсад суугаа суурин төлөөлөгч Виктория Сакителеко нар дээрх нөхцөлийн дагуу хүлээн авч хүлээн авагч орны харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулсан байна. Тус харилцан ойлголцлын санамж бичгийн дагуу Монгол Улсын ХХААХҮЯ нь НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын бүрэн тоноглогч, тохижуулсан түрээсийн байр, харилцаа холбоо, цахилгаан халаалт, цэвэр ус, унаа, жолооч, цалинжуулах болон бусад зардлыг хариуцахаар тохирсон байна. Мөн Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага түүний төлөөлөгч болон ажилтнуудад Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын бусад байгууллага түүний ажилтнуудад олгогдсоноос дутуугүй дархан эрх олгохыг зөвшөөрсөн болно оо. Ийнхүү НҮБ-аас НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас Монгол Улсад суух байнгын төлөөлөгчийн газрын хэмжээнд хүрсэн боловч олон улсын гэрээ хууль, эрх зүйн орчинд Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага хооронд суурин төлөөлөгчийн газар байгуулах тухай хэлэлцээргүй явсаар ирсэн байна аа.

Цаг үе ХХАА байгаль орчин, эрүүл мэнд, уур амьсгалын өөрчлөлт, хүрээлэн буй орчин зэрэг олон улс болон дотоодын нөхцөл байдал, шаардлагатай хэрэгцээтэй уялдуулан өнөөдөр Монгол Улсын Засгийн газар болон НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын хооронд НҮБ-ын хүнс Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас Монгол Улсад суух суурин Төлөөлөгчийн газрыг байгуулах тухай хэлэлцээрийг ийнхүү Монгол Улсын Их Хурлаар соёрхон батлах шаардлага үүссэн болно оо.

Тус хэлэлцээрийг байгуулснаар олон улсын гэрээ, хууль, эрх зүйн хүрээнд НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас Монгол Улсад суух суурин Төлөөлөгчийн газар нь НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас БНХАУ-д суугаа Төлөөлөгчийн газраас хамаарах бус бие даасан статустай болж НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас Монгол Улсын Засгийн газрын өмнө хүлээх үүрэг хариуцлага нэмэгдэхээр байна аа.

Хэлэлцээрийн төслийг дэмжиж өгөхийг хүсье ээ.

Энэ танилцуулгатай холбоотойгоор 2009-өөс 2025 оны хооронд Монгол Улсад НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага нийт 163 төслийг 176 сая, 477 мянган ам.доллараар санхүүжүүлэн төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн байдаг юм байна.

Асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Г.Тэмүүлэн: Энхбаяр сайдад баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад ХХААХҮЯ-наас ГХЯ-ны олон талт хамтын ажиллагааны газрын дэд захирал Отгонбаатар гэж хүн хүрэлцэн ирсэн байна. Энхбаяр сайд байгаа.

Ингээд хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Очирбат гишүүнээр тасалъя. Энхнасан гишүүн асуулт асууна. Энхнасан гишүүний микрофоныг.

Л.Энхнасан: Өдрийн мэндийг хүргэе. Энэ хэлэлцээр бол мэдээж нөгөө ОУБ орж ирж байгаа учраас энэ ХАА, хүнсний аюулгүй байдал хангахад нэлээн ач холбогдолтой хэлэлцээр гэж ойлгож байгаа. Энэ утгаараа Бээжингээс хариуцдаг байсан бол Улаанбаатарт төлөөлөгчийн газар байгуулснаар бол олон улсын төсөл хөтөлбөр нэлээн хэрэгжинэ гэж ойлгож байгаа. Харин ганц 2 асуух асуулт байна. Энэ Засгийн газраас үнэ төлбөргүй олгох байр тоног төхөөрөмж үйлчилгээний зардал гээд нэлээн олон энэ төлбөр улсын төсөвт ачаалал өгөхөөр ийм юмнууд харагдаж байна. Тэгэхлээр энэ байр тоног төхөөрөмж, тэр нөгөө машин, гарааш гэсэн энэ нарийн тооцооллуудыг хийсэн юм болов уу?

Хоёрдугаарт энэ хэлэлцээрийн хэмжээнд Монгол Улс хяналтаа яаж хийх юм бэ? Хяналтын механизм нь байгаа юм уу? Яагаад гэвэл энэ өмч хөрөнгө, архив, албан харилцаа нь бол Монгол Улсын эрх зүйн хяналтаас ангид байх юм байна. Тэгэхлээр нөгөө тайлагнал энэ тэр нь ил тод хариуцлагын асуудал үүсэж болзошгүй гэдэг үүднээс бол хяналтаа яаж хийх юм бэ гэсэн ийм 2 асуулт байна аа.

Г.Тэмүүлэн: Энхнасан гишүүний асуултад хариулъя. Хүнс ХААЯ-аас 9 номер. Гишүүний асуултад хариулъя.

Б.Отгонбаатар: Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн энэ өдрийн амрыг айлтгая аа.

Би ГХЯ-ны олон талт хамтын ажиллагааны газрын Отгонбаатар. Тэгээд Энхнасан гишүүний асуусан асуултад илүү манай ХААЯ-ныхан илүү түлхүү хариулсан нь зөв болов уу гэж бодож байна.

Г.Тэмүүлэн: Энхбаяр сайд та асуултад хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ нэгд НҮБ-ын дэргэдэх Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Юнеско эд нартай адилхан ХХАА-н гээд их томоохон байгууллага нь байдаг. Тэгээд Монгол Улс элсэн ороод 73 онд гишүүн болсон. Манай асуудлыг Бээжингээс хамаардаг байсан. Энэ тусгаар улсын хувьд өөрийнхөө асуудлыг энд байгаа НҮБ-ын олон улсын байгууллагуудаас өргөтгөх нь Монгол Улсад их ач холбогдолтой. Тэр үүднээсээ Бээжингээс наашаа шилжиж Монгол дахь албан ёсны суурин төлөөлөгчийн газар байгуулна. Дипломат эрх ямба нь бусад олон улсын байгууллагуудтай адилхан хэмжээнд л явна. Тэр хэмжээндээ л адил тусгайлсан тийм давуу эрх олгох юм байхгүй. НҮБ-ын төлөөлөгчийн газар ажилладаг улсууд яадаг билээ. Юнескод яаж ажилладаг билээ. ДЭМБ-д ажилладаг улсууд яадаг билээ тэр хүрээндээ л тэр эрх ямба дипломат хангамжаа эдлээд явна.

Эхний ээлжид нэг оффис тоноглох ширээ сандал, харилцаа холбоо гээд нэг ажлын албаны зардал гээд гарна. Тэрийг ХААЯ өөрийнхөө төсөвт суулгаад шийдвэрлэх бололцоотой гэдгээ Засгийн газрын хурлаар хэлэлцүүлж дэмжүүлсэн байгаа. Нэг удаагийн зарлага гарна. Энэ захиргааны бага зэргийн зардлаас илүүтэй Монгол Улсад хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүд нь нэлээн ач холбогдолтой өргөн хүрээг хамарсан олон салбарыг хамардаг. Түрүүн хэлсэн нийт 176 сая долларын төсөл хөтөлбөрийг Монгол Улсад хэрэгжүүлсэн буюу яг хэрэгжүүлээд явж байна.

Тэгээд манайд өөрийн төлөөлөгчийн газартай болсноор энэ төсөл хөтөлбөрийн тоо хэмжээ нэмэгдэх хүрээ тэлэх ийм бололцоотой байгаа. Ялангуяа энэ цөлжилтийн эсрэг олон улсын КОП-17 арга га хэмжээг Монгол Улсад хийхтэй холбоотойгоор энэ хүрээнд бид нар НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагатай хамтраад ажиллах чиглэлүүд маш өргөн байгаа. Тэгэхээр энэ төлөөлөгчийн газар бие даасан статустай байх нь их чухал байна гэж үзэж байгаа.

Г.Тэмүүлэн: Энхнасан гишүүн нэмж тодруулах уу?

Тэгье Энхнасан гишүүний микрофон өгье.

Л.Энхнасан: Яах вэ дипломат харилцааг ойлгож байгаа эрхийг. Би нөгөө нарийн тооцоо төсөв ер нь урьдчилж гарсан болов уу яах вэ? Тэгээд бас гэр бүлийн хүмүүс нь ялгаагүй дипломат эрхтэй байх юм байна лээ. Тэгэхлээр нөгөө гаалийн хөнгөлөлт, татварын хөнгөлөлт энэ тэр үзүүлэхээр харагдаж байна лээ. Тэгэхээр энэ дээр бусад ОУБ-тай жиших үү? Тэгээд хяналтын систем нь ер нь яаж байх юм бэ гээд тэрэн дээр бас.

Г.Тэмүүлэн: Гадаад яамнаас асуултад хариулъя. 9 номер.

Б.Отгонбаатар: Эрхэм гишүүдийн энэ өдөр өдрийн амар амгаланг айлтгая аа.

Сая Энхбаяр сайдын хэлсэнтэй ер нь утга адил тус хэлэлцээр соёрхон батлагдах шаардлагатай болсон үндсэн шалтгаан бол дархан эрх ямбын асуудал. Царай, цалин, урамшууллыг нь татвараас чөлөөлөх асуудал байгаа. Гэхдээ нэг зүйл нь юу вэ гэхээр одоо энэ байгууллага нь бол өнөөдөр Монгол Улсад үйл

ажиллагаагаа бүрэн хэмжээнд явуулж байгаа. Мөн энэ тус байгууллагад ажиллаж байгаа гаднын албан хаагчид маань дархан эрх ямбыг эдэлж байгаа. Гагцхүү энэ тус байгууллагын өөрийнх нь ОУБ-ын статус 2 улсын илүү тодорхой болсноороо үндсэндээ эдгээр албан хаагчдын дархан эрх ямба зүгээр үргэлжлэх л асуудал байгаа юм. Түүнээс биш шинээр олгож байгаа асуудал биш юм.

Г.Тэмүүлэн: Очирбат гишүүн асуулт асууя. Дараа нь Цогтбаатар гишүүн.

Г.Очирбат: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын төлөөлөгчийн газрыг байгуулна гэж байгаа юм. Тэгээд яах вэ зүгээр түрүүн бас Энхбаяр сайд хэлж байна. Олон сая доллар, дээрээс нь олон ч төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн гэж байгаа юм. Энэний бас нэг үр дүнг нь ямар төсөл хөтөлбөр дээр яаж яваад хэчнээн хэмжээний үр дүн гарсан юм бэ гэдэг юмаа уул нь эхлээд Энхбаяр сайд хэлчихсэн байсан бол их зүгээр байна гэж бодогдож байна. Нэг дэх асуулт.

Хоёрт гэх юм бол бас энэ төсөв дээр нэлээн дарамт ирэхээр шинжтэй байгаад байгаа. Түрүүн гишүүд дурдаж байна. Тэр барилга байгууламж, техник тоног төхөөрөмж, тавилга гарааш гээд бүгдийг нь хангах юм байна.

Хоёр гэх юм бол Засгийн газар жил бүр 100 мянган ам.долларын хандивыг Төлөөлөгчийн газарт өгч байх гэж байгаа. Энэ жил бүр 100 мянган долларыг НҮБ-ын төлөөлөгчийн газарт өгч байх гэдэг чинь ямар агуулгатай юм бэ? Энэ төлөөлөгчийн газрын байгуулснаараа бид нар тийм үүрэг хүлээж байгаа юм уу? Нэг бол энэ 100 мянган долларыг ямар шалтгаанаар ингэж оруулж ирсэн юм. Энгийг Энхбаяр сайд бас хариулчих байх гэж бодож байгаа юм. Мөн дээрээс нь 3 дугаарт гэх юм бол мэдээж одоо бид нар энэ НҮБ-ын олон ч төсөл хөтөлбөрт оролцсон байх. Тэгээд яг энэнтэй холбоотой нэгдсэн тайлан гэж байна уу? Энхбаяр сайд аа? Харин ийм нэг 3 асуулт байна. Тэгээд хариулахаар нь тодруулъя.

Г.Тэмүүлэн: Очирбат гишүүний асуултад хариулъя. Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Монгол Улс өөрөө энэ НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын гишүүнээр 1973 онд элсчихсэн. Тэгээд энэ гишүүнчлэлийн төлбөр буюу энэ татвараа төлж ирсэн бол энийгээ л үргэлжлүүлээд л төлөх асуудал яригдаж байгаа. Гол нь тэр. Бид үүргээ гишүүнчлэлд ороод үүргээ хүлээгээд ажиллаад байгаа. Нийт би хэлсэн 163 төсөл Монгол Улсад 176477820 мянган ам.доллар-ын төслийг Монгол Улсад 16 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн байгаа.

Тэгэхээрээ үр дүн нэлээн өндөр байдаг. Хамгийн гол нь энэ олон улсын хамтын нийгэмлэгт Монгол Улс нэгэнт гишүүн болоод үүрэг хүлээгээд гишүүнчлэлийнхээ татварын төлөө явж байгаа. Сая хэлсэн Дархан эрх, тэр дипломат эрх ямба нь үргэлжлээд явж байгаа. Ажлаа энэ чинь Монголд явуулж байгаа байгууллага байхгүй юу. Статусыг нь Монгол Улс дахь болгож байгаа юм. Бээжин дэх байгууллагаас Монголыг хамаардаг биш. Монгол Улсын нийслэлээс хамаардаг болгох л асуудал байхгүй юу даа. Тэр шинээр бий болгох, байгуулах гээд нэг тийм зүйл биш шүү дээ. Тэгээд статус өөрчлөгдөнө, үйл ажиллагаа нь үргэлжилнэ. Яг л НҮБ, Монгол Улс элссэнтэй холбоотойгоор НҮБ-ын дэргэдэх гол гол байгууллагууд Монгол Улс өөрөө элсэж үүрэг хүлээж, хамтын ажиллагаагаа хөгжүүлдэг шүү дээ. Тэрний л нэг элемент явж байгаа ажлууд.

Г.Тэмүүлэн: Очирбат гишүүн нэмж тодруулах уу?

Г.Очирбат: Тэгээд хэлэлцээрийн ач холбогдол гэсэн байгаа юм. Төсөл хөтөлбөрийн үр дүн дээшилнэ гэж байгаа юм. Ямар ямар төсөл хөтөлбөрүүдийн ямар үр дүн дээшилж байгаа юм. Энэ тоон үзүүлэлтээр гаргаж ирсэн юм байдаг юм уу, үгүй юм уу. Хөтөлбөр болон донор байгууллагуудын санхүүжилтийг нэмэгдүүлнэ гэж байгаа юм. Энэ жил буюу дараа жил ямар НҮБ-аас төсөл хөтөлбөрүүд байгаа юм. Тэрэнд нь манайх алинд нь оролцох гэж байгаа юм. Алиных нь үр дүн сайжрах юм. МАА газар тариалан уур амьсгалын тэсвэртэй байдал инновац зэрэгт илүү өргөн хүрээнд төслүүд хэрэгжүүлэх болно оо гэж байгаа юм. Яг энэ МАА, газар тариалан инновац дээр ямар ямар төслүүд НҮБ дээр яваад ямар төсөл нь илүү өргөн хүрээнд хэрэгжих гээд байгаа юм. Энхбаяр сайд аа.

Эд нарыг бас нэмэлтээр асуучихъя. Таны түрүүний асуултын хариултаа тал дутуу л авлаа шүү.

Г.Тэмүүлэн: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Нийт. 163 төсөл 176 сая долларын өртөгтэйгөөр хэрэгжсэн буюу хэрэгжиж байна. Ямар төслүүд хэрэгждэг вэ гэвэл аливаа төсөл хөтөлбөр манай Засгийн газар, Байнгын хороогоор ороод дэмжигдсэн тэр төсөл хөтөлбөрүүд л хэрэгждэг. Тэр хүрээндээ л бодлогынхоо нөгөө мөнгөний бодлогынхоо хүрээнд л шаардлагатай санхүүжилт эх үүсвэрээ тодорхойлоод л явна. Манай Засгийн газрын мөрийн хөтөлбөр, Монгол Улсыг дунд хугацаанд хөгжүүлэх 5 жилийн зорилт. Тэр хүрээнд багтсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхийн тулд бид нар зарим шаардлагатай тохиолдолд гадаад эх үүсвэр ашигладаг шүү дээ. Тэр хүрээндээ зохицуулаад Хөгжлийн яам бодлогоо гаргаад, Сангийн яам төсөв дээр уялдуулаад ингээд л хэрэгжүүлээд л явна. Ер нь ингээд энэ явж байгаа ажлыг Монголдоо оруулж ирснээр албан ёсны болсон нь илүү шууд харилцаа, шууд хамтын ажиллагаа илүү өгөөж нь илүү нэмэгдэх. Энэ тодорхой л доо. Тэгэхээр энэ 160.

Г.Тэмүүлэн: Нэмж микрофон өгье. Энхбаяр сайдад.

Ж.Энхбаяр: Би жагсаалтыг нь өгчихлөө. 163 төсөл байна.

Г.Тэмүүлэн: Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Өөр хүн байгаа юу? Цогтбаатар гишүүн. Хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя. Цогтбаатар гишүүн. Эрдэнэболд гишүүнээр тасаллаа. Цогтбаатар гишүүн.

Д.Цогтбаатар: Би юу ХААЯ-нд харин баяр хүргэмээр байна. Хуучин ер нь их олон жил энэ FAO -ийн юу оффисыг ер нь Монголд оруулж ирж ажиллахын төлөө явж байсан юм аа. Яагаад гэвэл энэ Монголын ёстой ХАА-н экспортод чинь амин чухал хэрэгтэй зүйл. Одоо энд Кодекс элементар 9 гэдэг тэр кодексыг чинь яг баталж ДЭМБ FAO 2-ын хүрээнд тэр юу энэ кодекс стандартууд батлагдсан байдаг юм. Энийг Монголд ХАА-нхаа салбарт эд нарын тусламжтайгаар нэвтрүүлэхгүйгээр Монголын бараа хүнсний ХАА-н бараа бүтээгдэхүүний экспортын тухай бодоод хэрэггүй. Энийг нэвтрүүлэх чинь яг тусгай бүүр мэдлэг хэрэгтэй байгаад байгаа байхгүй юу. Тэгээд энийг олон улсын тэр практик мэдээллийг чинь Монгол руу оруулж ирэхэд яг энэ байгууллагын туслалцаа дэмжлэг аягүй их хэрэгтэй байгаа юм. Хуучин бид нар зөвхөн тусламж дэмжлэг аваад яваад байсан байхгүй юу.

Одоо экспортыг нэмэгдүүлэхийн тулд манай дотоодын үйлдвэрүүд анхан шатнаасаа авхуулаад эцсийн бүтээгдэхүүн хүртлээ тэр стандартуудыг дагаж мөрддөг энэ системийг оруулж ирэхгүйгээр энэнд зүгээр Монголчууд өөрсдөө мэдээд оруулж ирэх маш хэцүү шүү.

Тийм учраас энэ FAO-тэй хамтарч ажиллаж байж энийг оруулах зайлшгүй шаардлага байгаа. Тэгээд энэ үүднээсээ бол нөгөө манайхан энэ хөрөнгө мөнгөний талаас нь хараад байх шиг байна. Экспортыг нөгөө уул уурхайгаас хамааралгүй экспортыг төрөлжүүлсэн эдийн засгийг хөгжүүлье гэж бодоод байгаа бол хамгийн түрүүний хөгжих боломжтой салбар чинь ХАА-н салбар. Тэгэхлээр энэ тал дээрээ бид нар энэ FAO-тай ажиллах аягүй чухал байгаа юм. Харин ч оруулж ирэхээр болчихсон байна. Тийм энэ чинь амар биш. Тэр шийдвэрийг гаргах чинь хэцүү шүү, нэг.

Хоёрт, нөгөө түрүүн асуултад би нэг зүйлийг нэмээд хэлчихмээр байна. Ер нь post country argument гэж НҮБ-ын гишүүн байгууллагууд НҮБ-ын хүрээний байгууллагууд тухайн хүлээж авч байгаа оронтойгоо гэрээ байгуулдаг энэ дотроо бол тодорхой яг привилежес энд иминентис гээд заалтууд орж ирдэг. Тэгэхдээ олон улсын хуулиараа Шведийн иргэнтэй холбоотой нэг хэрэг Палестинд гарсан.

Тэрнээс болоод олон улсын маргаан үүссэн байгаа. Тэрэн дээр гарсан олон улсын Кэйсийн прецидент юу гэж заасан байдаг вэ гэхээр НҮБ болон олон улсын хуулийн субъект бөгөөд энэ ажлаа хийхэд нь таарсан тэр эрх ямба, дархан эрхийг нь бол заавал өгч байж энэ үйл ажиллагаа явагддаг гээд. Манайхан тэгэхээр энэн дээр НҮБ-ын энэ байгууллагад ямар нэгэн эргэлзээгүй энэ эрх ямбыг нь өгөх ёстой. Яагаад гэвэл манайх өгөөгүй байсан ч олон улсын заншилт хуулиараа энэ чинь угаасаа олгогдчихсон байгаа зүйл. Тэр энжервис кэйс гэдэг дээр бүүр гараад олон улсын шүүхээр шийдэгдчихсэн байгаа кэйс байхгүй юу. Тэгэхлээр энийг нь бид нар гэрээгээрээ өөрсдөө уриад авчраад оруулж байгаа юм чинь энийг заавал өгөх ёстой гэж бодож байгаа.

Харин зүгээр тэнд нөгөө гэрээгээ хийхдээ ганц хоёр юман дээр хэтэрсэн юм хэрэв хүсээд байвал тэрийг нь өгөхгүй байж болно. Түүнээс тэр суурь дархан эрх ямбыг бид нар заавал өгөх ёстой. Энийг хэлсэн. Энэ чинь тэгээд НҮБ-ын хүрээний байгууллага учраас. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа Эрдэнэболд гишүүн үг хэлнэ.

С.Эрдэнэболд: Сая Цогтбаатар гишүүн ерөнхий төстэй агуулга хэлчихлээ. НҮБ яах вэ, энэ Бээжингээс Монголыг давхар хамаараад байгаа газруудаас энэ Монгол Улс тусгаар тогтносон улсын хувьд бас Монгол Улсдаа яг энэ бүтцийн нэгжийг нь байгуулахыг дэмжиж байгаа. Ялангуяа НҮБ талдаа. Зүгээр сая асуулт хариултын явцад нэг зүйлийг тодруулчихвал зүгээр юм байна гэж бодоод би сая үг хэлэхээр болчихлоо л доо. Энхбаяр сайд хэл яриандаа бол ингэж хэлж байна шүү дээ. Энэ гэрээн дээр байгаа 100 мянган доллар гэж байна шүү дээ. Энхбаяр сайд сая юу гэж хэлсэн бэ гэхээрээ эхний нэг удаагийн тэр оффис тоноглолын зардлыг яамныхаа төсөвт багтаагаад явуулчих боломжтой байна гэж хэлж байна лээ.

Гэтэл энэ гэрээн дээр болохлоороо жил болгон 100 мянган доллар, ам.доллар юм уу түүнтэй тэнцэх хэмжээний үндэсний төгрөгийг төсөвт тусгаад

олгож явах тухай ярьж байна л даа. Тэгэхээр энэ чинь нөгөө өөр асуудал болоод явчхаж байгаа гэж ойлгогдоод байгаа юм. Тэгээд цаашдаа яг энэ төсөв хаана ямар төсөвт суух юм. Гадаад харилцааны яам энийг хариуцуулж, суулгах юм уу, эс үгүй бол Засгийн газарт байх юм уу яг энэ чиглэлийн тусгайлсан төсөв байх юм уу гэдгийг тодруулаад хэлчихвэл зүгээр байгаад байгаа юм. Зарчмын хувьд дэмжиж байгаа. Гэхдээ бас нөгөө хүмүүст эргэлзээ тээнэгэлзээ үзүүлэхгүй. Эргэлзээ тээнэгэлзээ бага үзүүлэх үүднээс энийг нь нэг ялгааг нь гаргаад хэлчихвэл зөв байх аа. Тодруулаад хэлчихвэл уг нь зүгээр юм байна лээ. Яагаад гэхээр сайд бол нэг удаагийн гэж хэлж байгаа. Гэтэл гэрээн дээр чинь жил болгоны тогтмол зардал гэж байгаа. Энэ зардал хаанаас гарах юм бэ гэдгийг л тодруулаад хэлчих гэж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Энхбаяр сайд үг хэлэх үү. Тэгье Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Ач холбогдол талаас нь гишүүд ярилаа. Тэр зардалтай холбоотой асуудлыг 2 хувилбар байдаг. Гадаад яаман дээр төсөв дээр суулгаад нэг явдаг. Эсвэл харьяа манай яам зардалдаа суулгаад аваад явах юм. Хэрвээ энэ асуудал Их Хурлаар хэлэлцэгдээд дэмжихсэн тохиолдолд Засгийн газар төсвийнхөө аль хүрээнд яаж багтаагаад явахаа шийдэх байх.

Г.Тэмүүлэн: Гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулахаар байгаа. Санал хураалтад бэлтгэе.

Гишүүд хуруугаа эхлээд уншуулаарай.

Бүгд бэлэн болсон байна.

Санал хураалтыг явуулъя. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын төлөөлөгчийн газар байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага хоорондын хэлэлцээрийн төслийг зөвшөөрч гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулна аа.

Ингээд энэ томъёоллоор санал хураалтыг явуулъя.

Гишүүд саналаа өгөөрэй.

87.5 хувиар дэмжигдлээ.

Ингээд уг асуудлыг хэлэлцсэн талаарх манай Байнгын хорооны тэмдэглэл, санал хураалт, санал дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлнэ ээ.

Ингээд энэ асуудлыг хэлэлцэж дууслаа.

15.14 цаг

Хоёр дахь асуудалдаа орцгооё.

Мэдээлэл сонсохоор байгаа.

Сангийн яамныхныг оруулаарай.

Гадаад зээл тусламжийн хэрэгжилт нөхцөл байдлын талаарх Сангийн сайдын мэдээллийг сонсохоор байгааг байгаа.

Хэлэлцэж байгаа албан тушаалтнуудыг оруулна уу?

Сангийн сайд байна уу? Ер нь энэ асуудлыг хэлэлцэж эхлэхээс өмнө та бүхэнд мэдээлэл өгье. Манай Байнгын хорооны гишүүдээс өнгөрсөн хаврын чуулганаар хэд хэдэн хүсэлтүүдийг ирүүлсэн.

Нэгдүгээрт ерөнхийдөө бол саяын энэ олон улсын гэрээ хэлэлцээртэй холбоотой асуудлууд дээр, тэдгээрийн хэрэгжилттэй холбоотой асуудлууд дээр, Гадаад яамны мэдээллийг бол сонсьё гэсэн хүсэлтийг бол ирүүлсэн байгаа.

10 сарын эхний 7 хоногт Гадаад яамны мэдээллийг бол сонсохоор байгаа. Мөн одоо манай Байнгын хороогоор, 10 сарын эхээр Европын сэргээн босголтын банк болоод Азийн хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээрүүд орж ирэхээр байгааг байгаа юм. Энэнтэй холбогдуулаад эдгээр хэлэлцээрүүд орж ирэхээс өмнө мөн хаврын чуулганаар Байнгын хороодын гишүүдээс гаргасан саналын дагуу гадаад зээл тусламжийн талаарх мэдээллийг, Сангийн сайдын мэдээллийг бол сонсьё оо гэдэг энэ хүсэлтийг бол ирүүлсэн байгаа.

Ингээд энэ дагуу энэ 7 хоног дээр хэлэлцэх асуудлын жагсаалт дээр орсон байна. Мөн манай Байнгын хороодын гишүүдээс гаргасан саналын дагуу эрчим хүчний аюулгүй байдалтай холбоотой эрчим хүчний салбарын өнөөгийн нөхцөл байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх эрчим хүчний сайдын мэдээллийг бол сонсьё гээд 10 сарын 1-ээр ЭХЯ-аас салбарынхаа талаарх мэдээллийг бол бэлтгээд манай Байнгын хороонд бол танилцуулахаар бол байгаа. Мөн ЭМЯ болоод ХНХЯ, ХЗДХЯ-д хамтраад манай Байнгын хороонд удмын сангийн аюулгүй байдалтай холбоотой, хүн ам зүйн бодлоготой холбоотой асуудлаар мэдээллийг бол 10 сарын эхний 7 хоногт бол хийхээр байгааг байгаа юм.

Тэгэхээр бол 3, 4 чиглэлээр бол мэдээллүүд ингээд хийгдэхээр байгаа гэдгийг бол та бүхэндээ хэлэх байна.

Өнөөдрийн энэ хэлэлцэх гэж байгаа Гадаад зээл тусламж хэрэглэгчдийн талаарх мэдээлэлтэй холбоотой асуудал маань бол дараагийн 7 хоногоос манай Байнгын хороо болоод Төсвийн байнгын хороодууд дээр орж ирж байгаа Европын сэргээн босголтын банк, Азийн хөгжлийн банктэй холбоотой зээлийн хэлэлцээрүүдээс өмнө ер нь том зургаараа үндсэндээ энэ Засгийн газар болоод улсын өр зээл үнийн үлдэгдэлтэй холбоотой асуудлууд, мөн бонд, өрийн баталгаатай холбоотой асуудлууд ер нь ямар түвшинд явж байгаа, гарч байгаа хүндрэлтэй холбоотой асуудлууд юу байна.

Засгийн газрын өрийн үйлчилгээ болоод хүүгийн зардалтай холбоотой асуудлууд гээд нэгдмэл нэгдсэн мэдээллийг бол Байнгын хорооны гишүүд бол авъя гэсэн хүсэлтийг өгсөн. Энэ дагуу бид нар Сангийн яаманд хандаад 2 мэдээллийг бол авсан байгаа. Нэг нь бол 7 сард чуулган цуглахаас өмнө гишүүдэд бол Сангийн сайдын мэдээллийг хүргүүлсэн. Сая нэмэлтээр өнгөрсөн 1991-ээс 2024 оны хооронд ашигласан гадаад зээлийн төслийн жагсаалт мэдээллийг бол мөн Засгийн газраас аваад гишүүдэд ингээд өгүүлсэн байгаа гэдгийг бол хэлэх байна.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалдаа оръё. Сангийн яамны ТНБД Ганбат дарга, Сангийн яамны хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Жамьяншаравын Дэлгэржаргал дарга, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох, Сангийн яамны хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг гэсэн бүрэлдэхүүнтэй байгаа юм байна.

Сангийн сайд байгаа болов уу? Өвчтэй байгаа? Та хийхээр байгаа юм уу? Учрал Сайд байхгүй юу ядаж. Ойлголоо.

Тэгэхээр угаасаа Улсын Их Хурлын тухай хуулиараа, Дэгийн тухай хуулиараа яг угаасаа манай Байнгын хорооны эрхлэх асуудлынхаа хүрээнд бол бас ажлаа тайлагнадаг байгууллагын сайд нь гэж бол ярьсан байгаа. Тэгэхээр бол орлож өөр сайд танилцуулах асуудал бол байхгүй. Сангийн сайд өөрөө яг энэ тусгайлсан асуудал учраас өөрөө энэн дээр тайлбар мэдээллүүдээ бол өгөх нь зөв байх гэсэн байр суурьтай байна.

Нөгөө талдаа өрийн удирдлагын асуудал бол бас Эдийн засгийн хөгжлийн яамтай хамааралтай асуудал. Эсвэл Учрал сайд бол байж болох байсан. Тэгэхээр Бат-Амгалан сайд та бол танилцуулах боломжгүй байна аа. Тэгэхээр энэ асуудлыг Сангийн сайдыг ирэх хүртэл бол дараагийн 7 хоног хүртэл хойшлуулж байна аа.

Тэгээд дараагийн 7 хоногт 2 Байнгын хорооны хамтарсан хуралдааны өмнө тусдаа бол мэдээллийг нэгдсэн байдлаар бол сонсох нь зүйтэй гэсэн саналтай байна. Гишүүд дэмжиж байгаа байх тиймээ? Ингээд энэ асуудлыг дараагийн 7 хоног хүртэл хойшлуулж байна аа.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлууд маань дууссан байна. Хүрэлцэн ирсэн гишүүд, ажлын хэсгийнхэнд баярлалаа.

Өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье ээ.

15.20 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА